

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАРТ ХОЛБОГДОХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 11 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын байгууллагад холбогдох арга хэмжээний 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан байгууллагад хамаарах 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэв.

Тухайн арга хэмжээний биелэлт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, үйл ажиллагааг эрчимжүүлж, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулан үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тул үнэлгээ буурч байна.

Дүгнэлт, зөвлөмж:

Байгууллагад хамаарах 1 арга хэмжээний хэрэгжилт “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай дүгнэгдлээ.

Хэрэгжилт хангалтгүй байгаа нь “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” системийг хөгжүүлэхээр “Гэрэгэ системс ХХК”-тай байгуулсан гэрээний гүйцэтгэл хэт удаашралтай байснаас гэрээг цуцалж, системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэх компанийг дахин сонгон шалгаруулах шаардлага үүссэнтэй холбоотой.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” ажлын хэрэгжилт удааширч байгаа тул зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэн түргэн шуурхай, нягт хамтран ажиллаж, жилийн эцэст зорилт, арга хэмжээний биелэлтийг бүрэн ханган ажиллах шаардлагатай байна.